

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Д/д	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Биелэлт
1.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	Төлөвлөгөөний тоо	1	1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажилласан.
2.	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	2	3	<ul style="list-style-type: none"> • Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хамтран зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг танилцуулах сургалтад байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан. • 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр тус газрын нийт албан хаагчдад Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, Ёс зүйтэй албан хаагч байхын ач тус сэдвийн хүрээнд танилцуулах сургалт зохион байгуулсан. • 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга нарт төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулсан.

3.	Шинээр ажилд орсон албан хаагчдад ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулахад холбогдох нэгжтэй хамтран ажиллах	Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	8	21	<ul style="list-style-type: none"> Захиргаа удирдлагын газрын хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэнтэй хамтран тус газарт шинээр томилогдсон албан хаагчдад ёс зүйн асуудлаар 3 удаагийн сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл өгч 12 албан хаагчийг хамруулсан. 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр шинээр томилогдсон 9 удирдах албан тушаалтанд ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулсан.
4.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	Дүгнэлтийн тоо	Тухай бүр	5	<ul style="list-style-type: none"> 2024 онд 2 иргэн, 7 албан хаагчаас ёс зүйн дэд хороонд гомдол ирүүлсэн бөгөөд тус гомдлыг 5 нь бичгээр, 4 нь цахим хэлбэрээр хүргүүлсэн. Гомдолд нийт 6 албан хаагч холбогдсоны 2 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй албан хаагч байсан. Үүнээс төрийн захиргааны удирдах албан тушаалтан 1, төрийн үйлчилгээний 4 албан хаагчийн 1 нь удирдах албан тушаалтан байна. 2024 онд ирсэн гомдлыг хянан шалгаж ёс зүйн зөрчил тогтоогдоогүй 4, зөрчил тогтоогдсон 5 дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн ба тус дүгнэлтэд үндэслэн 1 албан хаагч өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөж 1 албан хаагч хамт олноос уучлал гуйн 1 албан хаагч байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах, 1 албан хаагч гомдол гаргагчид уучлалт гуйхыг үүрэг болгохоор шийдвэрлэсэн. 5 гомдлыг хянан шийдвэрлэж дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.
5.	Холбогдох нэгжүүдэд ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх;	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	5	5	Нийт албан хаагчдын дунд байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгааны

					үр дүнд үндэслэн байгууллагын бүтцийн 5 нэгжид зөвлөмж хүргүүлсэн.
6.	Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа хийх	Судалгааны тоо	2	2	<ul style="list-style-type: none"> • Нийт албан хаагчдын дунд байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа авч үр дүнг нэгтгэн удирдлагад танилцуулсан. Тус судалгаанд нийт 116 албан хаагч хамрагдаж байгууллагын дотоод уур амьсгал, үүсэж байгаа болон ирээдүйд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, эрсдэлийг тодорхойлон холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. • Тус судалгааны үр дүнд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгийн их эрсдэлтэй байгаа нэгж болох Захиргаа удирдлагын газрын албан хаагчдын дунд ярилцлага хийх, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой судалгааг хамт олны үнэлгээний хуудасны загвараар авч нэгтгэсэн.
7.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх;	Тайлангийн тоо	2	3	<p>Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд:</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/85 дугаартай албан бичгээр Ёс зүйн дэд хороог байгуулсан тушаал, 2024 онд Ёс зүйн дэд хорооны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, 1 дүгээр улирлын тайланг хүргүүлсэн. • 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/204 дугаартай албан бичгээр 2 дугаар улирлын тайланг хүргүүлсэн. • 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 01/265 дугаартай албан бичгээр 3 дугаар улирлын тайлан,

					“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын төсөлд санал хүргүүлсэн.
8.	Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, Мэргэжлийн холбоо, салбарын удирдах эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, албан даалгавар, судалгаа, өмнөх жилийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ, тайланд үндэслэн нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийн талаар байгууллагын Чанар хяналтын газарт зөвлөмж хүргүүлэх	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	5	6	Нийт албан хаагчдын дунд байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгааны үр дүнд үндэслэн албан хаагчдын харилцаа хандлага, үүрэг даалгаврын тэгш бус хуваарилалт, ур чадварын үнэлгээний шударга бус байдалтай холбоотой зөрчил гарах эрсдэлийг бууруулах, нэгжийн дотоод зохион байгуулалт, харилцаа хандлага, ёс зүйтэй байдлыг эрхэмлэж, дээрх асуудалтай холбоотой бусад нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль, тогтоол, дүрэм, журмыг хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг Чанар хяналтын газар болон Захиргаа удирдлагын газар тус тус хүргүүлсэн. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай зөвлөмжийг байгууллагын бүтцийн бүх нэгжид хүргүүлсэн.
9.	Ээлжит хуралдааныг жил бүрийн 6, 12 дугаар сарын сүүлийн долоо хоногт зохион байгуулна.	Хуралдааны тоо	2	2	2024 оны 06 дугаар сарын 28, 12 дугаар сарын 31-ний өдрүүдэд дэд хорооны ээлжит хуралдааныг зарлаж 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, цаашид хийж хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, анхаарах зүйлс, байгууллагын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллах, талаар хэлэлцсэн.
10.	Ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол, мэдээллийг хянан	Хянан шийдвэрлэсэн	Тухай бүр	15	2024 онд Ёс зүйн дэд хороонд нийт 9 гомдол ирж 5 дүгнэлт хүргүүлж 4 гомдлыг хянан шалгаж байна. Нийт 15 удаагийн

	шийдвэрлэх хуралдааныг тухай бүрд нь зохион байгуулах	гомдол мэдээллийн тоо			хурдыг зохион байгуулж өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.
11.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;	Мэдээллийн тоо	5	5	Байгууллагын албан ёсны цахим хуудаст: <ul style="list-style-type: none"> • Ёс зүйн дэд хороо байгуулах тушаал; • 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө; • Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, зөрчил гаргасан талаарх гомдлыг хянан шийдвэрлэсэн талаарх мэдээлэл; • Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль; 2024 оны улирлын тайланг тус тус байршуулж олон нийтэд мэдээлж ажилласан.
12.	Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах;	Арга хэмжээний тоо	2	4	<ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллага, хамт олны сэтгэл зүйд эергээр нөлөөлөх иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор “Төрийн албанд танил талаараа бус мэдлэг чадвараар өрсөлддөг тогтолцоог хэвшүүлэхийн төлөө” сэдэвт контент бэлтгэж байгууллагын албан ёсны фэйж хуудсаар дамжуулан түгээсэн. • Сэтгэл судлалын ухааны доктор /PhD/ Б.Баярмааг урьж 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр нийт албан хаагчдад “Байгууллагын сэтгэл зүй” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. • Байгууллагын нийт 18 албан хаагчийн сэтгэл зүйн тогтвортой байдалд оношилгоо хийж ганцаарчилсан зөвлөгөө өгч мэдээллээр хангаж ажилласан. • Байгууллагын 2024 оны хамгийн ёс зүйтэй 3 албан хаагчийг шалгаруулж алдаршуулах арга хэмжээг зохион байгуулсан.

13.	Иргэд, байгууллагын албан хаагчдыг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх.	Зөвлөгөө мэдээллийн тоо	4	6	Төрийн албан хаагчийн ёс зүй, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг танилцуулах сургалтыг 4 удаа зохион байгуулж нийт албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн гомдол ирүүлсэн 2 иргэнд шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл өгч ажилласан.
-----	--	-------------------------	---	---	--